



**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ”-ний хэрэгжилтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар
мэдээлэл**

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
Ахлах мэргэжилтэн О.Мөнхсүрэн
2020.01.13*

ᠬᠢᠨᠠᠯᠲᠤᠰᠢᠨᠵᠢᠯᠢᠭᠡᠢ, ᠦᠨᠢᠯᠭᠡᠨᠢᠶᠢ ᠦᠷ ᠳᠦᠨ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгож, **ЗГ-ЫН мэдээллийн цахим санд** байршсан:

нийт 61 зорилтын 89 арга хэмжээ-г хяналтанд авч, хэрэгжилтэд ХШҮнэлгээг хийлээ.

Хяналт-шинжилгээ - үнэлгээний үр дүн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн



Он	Зорилтын тоо	Арга хэмжээ
2017 он	66	97
2018 он	64	93
2019 он	61	89
Дундаж	63.6	93

Хяналтад авсан зорилт, арга хэмжээний тоо



Урьдчилсан судалгаа - 2019

Үнэлгээний дүгнэлт

97.18 % буюу **4.85** оноо

(2018 он: 97.0% буюу 4.85 оноо)

Үнэлгээг бодлогын *төрөл, хэрэгжүүлэгч*
нэгжээр нь харуулбал:


№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс				Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан	
			Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	Нийгмийн бодлого	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого		
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	61	18	12	18	5	8	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	89	28	15	30	7	8	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	79	26	14	27	7	4
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	4	-	1	1	-	2
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	2	-	-	-	-	2
		Үр дүнгүй буюу 0.0%	-	-	-	-	-	-
		Үнэлэх боломжгүй	4	2	-	2	-	-
Хэрэгжилтийн хувь, оноо		97.18% буюу 4.85 оноо	100% буюу 5.0 оноо	98.12% буюу 4.9 оноо	98.92% буюу 4.94 оноо	100% буюу 5.0 оноо	77.50% буюу 3.87 оноо	

№	Хэрэгжилт	Бүгд	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
			Хууль эрх зүйн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Орон нутгийн өмчийн газар	Захирагчийн алба	Мэдээлэл технологийн алба	
1.	<u>Хяналтанд авсан нийт зорилтын тоо</u>	61	3	34	16	2	5	1	
2.	<u>Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо</u>	89	3	57	19	3	6	1	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	79	3	52	15	3	5	1
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	4	-	1	3	-	-	-
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	2	-	-	1	-	1	-
		Үр дүнгүй буюу 0.0%	-	-	-	-	-	-	-
		Үнэлэх боломжгүй	4	-	4	-	-	-	-
<u>Хэрэгжилтийн хувь, оноо</u>		97.18% буюу 4.85 оноо	100% буюу 5.0 оноо	99.43% буюу 4.97 оноо	92.10% буюу 4.6 оноо	100% буюу 5.0 оноо	90.0% буюу 4.5 оноо	100% буюу 5.0 оноо	

2019 онд хяналтад авсан арга хэмжээний тоог бодлогоор нь 2017, 2018 онд хяналтад авсан тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Бодлого/ он	Нийт арга хэмжээ	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	Нийгмийн бодлого	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого	Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан
2017 он	97	29	21	31	7	9
2018 он	93	30	16	31	7	9
2019 он	89	28	15	30	7	8
Дундаж	93	29	17.3	30.6	7	8.6

Хяналтад авсан арга хэмжээний тоо



2019 онд хэрэгжүүлэх нэгжээр хяналтад авсан арга хэмжээг 2017, 2018 оны хяналтад авсан арга хэмжээтэй харьцуулж харуулбал:

Он	Нийт арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
		Хууль эрх зүйн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Орон нутгийн өмчийн газар	Захирагчийн алба	Мэдээлэл технологийн алба
2017 он	97	2	58	25	1	3	7	1
2018 он	93	2	59	19	1	3	7	2
2019 он	89	3	57	19	-	3	6	1
Дундаж	93	2.3	58	21	0.6	3	6.6	1.3

***ХЭРЭГЖИЛТ САЙТАЙ, ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН, ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТТЭЙ
БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ (19)***

Танилцуулгаас харах боломжтой.

БҮРЭН ЭРХИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИЛТ УДААШИРЧ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Үүнд:

6.7.2 Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор цахилгаан дамжуулах төв шугамыг тойрог схемд шилжүүлэх (ЗА) **онцгой анхаарах**

6.7.4 Багш хотхон” болон “Боловсрол хотхон”-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх (НБХ)

6.7.6 “Спорт цогцолбор”-ын төвийг бүрэн ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлэх (НБХ)

ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ АРГА ХЭМЖЭЭ (4)

ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ-4

24	<p>2.88. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	5	<p>Газар хөдлөлтийн лаборатори байгуулах, техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулах</p>	2017 - 2020	ХОХБТХ ГХБХБГ	-	<p>Газар хөдлөлтийн үйлчлэлд барилга байгуулам-жийг тооцох, төлөвлөхтэй холбоотой хийц, элементийн бат бэх, тогтворыг туршиж лаборатори байгуулагдаж, барилга, байгуулам-жийн чанар, аюулгүй байдал сайжрах, хүн амын аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэх</p>	<p>Дархан-Уул аймагт газар хөдлөлтийн чичирхийлэл хэмжих лаборатори байгуулах шийдвэр гараагүй. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл бууруулах байнгын ажиллагаатай зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулсан. 2019 оны төлөвлөгөө гаргаж батлуулан ажилласан. Аймгийн хэмжээнд 1970 оноос өмнө баригдсан газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн судалгааг гаргасан. Тус аймгийн Газар хөдлөлтийн бичил мужлалын зургийн ажлыг "Инж геотех" ХХК гүйцэтгэн бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн бичил мужлалын зурагтай холбоотой материалыг аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн.</p>	ҮБ
26	<p>2.91. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө</p>	4	<p>Цэвэрлэх байгууламжийн хяналтын лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон</p>	2019 - 2020	ХОХБТХ	Хөрөнгө төсөв	<p>Аймгийн төвийн лаборатори йн тоног төхөөрөмж шинэчлэгдэ</p>	<p>Дархан хотын бохир усны менежмент сайжруулах МОН3244/3245 төслийн хүрээнд 2020 онд цэвэрлэх байгууламж бүрэн шинэчлэгдэж шаардлагатай лабораторын тоног төхөөрөмж суурилагдах болно.</p>	ҮБ

ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ АРГА ХЭМЖЭЭ (4)

55	<p>4.2.2. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ.</p>	1	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай эрх зүйн орчны боловсронгуй болгож, тогтвортой санхүүжилтийн механизм бүрдүүлэх, экосистемийн үйлчилгээнд тулгуурласан хамгаалалтын менежментийг нэвтрүүлэх</p>	2017 - 2019	ХОХБТХ	-	<p>Тогтвортой санхүүжилтийн механизмыг тодорхойлж хамгаалалтын захиргаадад нэвтрүүлэх</p>	<p>БОАЖЯамнаас "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх чиглэл орон нутагт ирээгүй байна.</p> <p>Дархан-Уул аймгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах зорилгоор 12 нэгж талбар бүхий нийт 1112.37 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд 15 жилийн хугацаатайгаар авсан. Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар 16 байгаа ба холбогдох дүрэм журмыг мөрдүүлэн ажиллаж байна.</p>	ҮБ
62	<p>4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх.</p>	4	<p>Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах</p>	2016 - 2020	ХОХБТХ	-	<p>Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийг батлуулж, холбогдох стандартыг шинэчлэх, аргачлал боловсруулж эхлэх</p>	<p>Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас "Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр"-ийн төсөл орон нутагт ирээгүй байна.</p> <p>2017-2019 онд аймгийн хэмжээнд 154.84 га газарт техникийн нөхөн сэргээлт, 20.4 га газарт биологийн нөхөн сэргээлт хийгдсэн.</p> <p>2017 онд 26.4 га газарт техникийн нөхөн сэргээлт, 2018 онд 46.54 га газарт техникийн, 1.8 га газарт биологийн нөхөн сэргээлт, 2019 онд 72.9 га газарт техникийн, 18.6 га газарт биологийн нөхөн сэргээлт хийгдсэн.</p> <p>Мөн 2019 онд 4 ААНэгж нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн буруутай үйл ажиллагаанаас болж эвдэрч эзэнгүй орхигдсон 16.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	ҮБ

40% ҮНЭЛГЭЭТЭЙ АРГА ХЭМЖЭЭ (2)

40% ҮНЭЛГЭЭТЭЙ-2

83	6.7.2. Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиглагаг хангах зорилгоор цахилгаан дамжуулах төв шугамыг тойрог схемд шилжүүлнэ.	1	Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиглагаг хангах зорилгоор цахилгаан дамжуулах төв шугамыг тойрог схемд шилжүүлэх	2017 - 2020	ЗА	200,0	110 кВ-ын 12 км агаарын шугам барих	Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиглагаг хангах зорилгоор өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг тойрог схемд шилжүүлэхэд шинээр барьж байгуулах шаардлагатай 110/35/6кВ-ийн дэд станц 2 ш, 110кВ-ийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 22 км агаарын шугамын тойм зураг хийгдсэн. аймгийн кадастерийн зураг трассын тэмдэглэгээ хийгдсэн.	40%
85	6.7.4. "Багш хотхон" болон "Боловсрол хотхон"-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1	"Багш хотхон" болон "Боловсрол хотхон"-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2017 - 2020	НБХ ХОХБТХ	25,0	"Боловсрол хотхон"-ыг цэвэр бохир ус, дулаан, цахилгаан, холбооны нэгдсэн системд холбох	2015 онд Боловсрол хотхоны техникэдийн засгийн үндэслэлийг зургийн даалгаврын хамт аймгийн ерөнхий архитектур, захирагчийн албатай хамтран боловсруулсан. Үүнийг үндэслэн БСУГ-т багш хотхоны зураг төсвийг боловсруулах, зөвлөх үйлчилгээний аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан. Сонгон шалгаруулалтаар "Ноёдын туурь" ХХК шалгарч, багш хотхоны ерөнхий төлөвлөгөө эскиз зургийг боловсруулж батлуулсан. Боловсрол хотхоны бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ЕБС-ийн болон СӨББ-ын багш нарын амьдрах нөхцөлийн буюу орон сууцны судалгаа авсан. Судалгаагаар орон сууцанд орох хүсэлтэй 501 багш байна. Энэ хүрээнд төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууцжуулах ажлыг эхлүүлж, аймгийн Засаг даргын 2018 оны 01 А/199 дүгээр захирамжаар газрыг олгож барилгын ажлыг гүйцэтгэх тендерт "Хэрлэн зураглал" ХХК шалгарч 2019 оны 4 дүгээр сараас барилгын ажлыг эхлүүлсэн ба ажлын гүйцэтгэл 35,2%-тай байна. Тус 216 айлын орон сууцанд багш нар хамрагдахаар захиалга өгсөн байна.	40%

70% ҮНЭЛГЭЭТЭЙ АРГА ХЭМЖЭЭ (4)

37	<p>3.2.48. <u>Музейн хадгалалт, хамгаалалтын шаардлагыг олон улсын стандартад хүргэж, хэрэгжилтийг хангана.</u></p>	2	<p><u>Улсын болон орон нутгийн 10 музейг стандартын шаардлага хангасан сан хөмрөгтэй болгох</u></p>	<p>2019 - 2020</p>	НБХ	-	<p>Улс, орон нутгийн 5 музейг стандартын шаардлага хангасан сан хөмрөгтэй болгох</p>	<p>Дархан-Уул аймгийн Музейн сан хөмрөгийн тооллогын 2019 оны 1, 2 сард тоолсон. Музейн үндсэн хөрөнгөд нийт 950.8 сая төг, Музейн хөдлөх дурсгалын үндсэн хөрөнгө 561.1 сая төгрөг тус тус бүртгэгдсэн байна. 2019 оны Улсын тооллогоор сан хөмрөгийн 911 дэсийн 1300 үзмэр тоологдлоо. Аймгийн Музей нь стандартын бус барилгад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд шаардлага хангасан сан хөмрөгийн өрөө байхгүй боловч олон улсын стандартад ойртуулж үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг өөрсдийн нөөц боломжоо ашиглан хийлээ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сан хөмрөгийн өрөөний үзмэрийн тавиуруудыг шүлтлэггүй даавуугаар бүрж үзмэрийг гэмтээх эрсдэл, тоос шороо нарны тусгалаас хамгаалж байна. 2. Сан хөмрөгт хадгалагдаж буй 12 ширхэг уран зурагт цуу ямбуу даавуугаар уут оёж, хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. 3. Сан хөмрөгт буй 40 ширхэг жижиг үзмэрүүдийг зориулалтын хөөсөнцөрт суулгаж хайрцаганд хийж хамгаалалтыг сайжрууллаа. 4. Нарны гэрлийн тусгалын нөлөөг бууруулж үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүднээс Музейн 2 давхарын цонхонд нарны гэрлийг саармагжуулж бууруулдаг шилэн наалт наалаа. 5. Үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж 5 дэсийн үзмэрт анхан шатны сэргээн засварлалт хийгдлээ. <p>Сан хөмрөгийг баяжуулах зорилгоор "Найрамдлын Дархан" хотын бүтээн байгуулалтад залуу нас, хүч чадал, оюун ухаанаа зориулж өнөөдрийн Дархан хотыг үндэс суурийг тавьсан "Илгээлтийн эзэд" тухайн үеийн залуучуудын /1961-1990/ аж амьдрал, түүх, алдар гавьяаг сурталчилсан үзмэр цуглуулгын жагсаалтыг "Үзмэр худалдан авах Зөвлөл"-ийн хурлаар шийдвэрлэж, Дархан-Уул аймгийн иргэдээс ирсэн түүх, угсаатны зүйн 29 дэсийн 34 ширхэг үзмэрийн саналыг албан тоотын хамт хүргүүлж ажилласан.</p>	70%
----	---	---	---	----------------------------	-----	---	--	--	-----

70% ҮНЭЛГЭЭТЭЙ АРГА ХЭМЖЭЭ (4)

53	<p>4.1.6. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</p>	5	<p>Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх</p>	<p>2016 - 2020</p>	ХОБХТХ	-	<p>Төслийн хүрээнд 900-аас доошгүй өрхөд эко ариун цэврийн байгууламж суурилуулах</p>	<p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН32/44 төслийн хүрээнд аймгийн Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг 2017 онд "PFEIFFER&EMIT JV" ХХК-тай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлийг хангуулан ажиллаж байна.</p> <p>2019 онд "Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил"-ын гүйцэтгэл 70%-тай, Улсын төсвийн 6,4 тэрбум төг-ийн хөрөнгө оруулалтаар Дархан сум 5-р багийн гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэл 30%, Улсын төсвийн 4,2 тэрбум төг-ийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 7, 8-р багийн гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэл 80%, Улсын төсвийн 8,7 тэрбум төг-ийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 6, 7-р багт ус дулаан дамжуулах 12 төв, ус дулааны 1-р контурын 3,9 км, бохир усны 4,7 км төв магистраль шугамуудын ажлын гүйцэтгэл 30% -тай байна.</p> <p>Дээрх ажлууд хийгдсэнээр Дархан сумын 5-р багийн 400, 6, 7-р багийн 1100, 7, 8-р багийн 450 айл өрх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдож, дулааны хамааралгүй схемд шилжинэ.</p>	70%
86	<p>6.7.6. "Спорт цогцолбор"-ын төвийг бүрэн ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлнэ.</p>	1	<p>"Спорт цогцолбор"-ын төвийг бүрэн ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлэх</p>	<p>2017 - 2020</p>	НБХ		<p>Барилга угсралтын ажлын явц нэмэгдэх</p>	<p>"Спорт соёл үйлчилгээний цогцолбор"-ын барилгын ажилд 2018 онд Улсын төсвөөс 4.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамны захиалгаар баригдаж байгаа 2200 хүний суудалтай "Спорт соёл үйлчилгээний цогцолбор"-ын барилгын ажилд 2019 оны Улсын төсөвт 1.7 тэрбум төгрөг суугдсан.</p> <p>Барилгын зураг төсөвт тусгагдаагүй</p> <ul style="list-style-type: none"> ✓ ABCDE блок-интерьер /концепт дуусаагүй- акустик, дуу дуу шингээх материал, хана баганын зөөлөвчтэй хамгаалалт ✓ А блок-Галын утаа сорох систем ✓ А блок-ТВ шууд дамжуулалтын өрөө, шүүгчийн өрөө, VIP өрөө, эмчийн өрөө, техникийн өрөө, ажилчдын өрөө, ✓ ABCDE блок-гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлага төлөвлөх ✓ ABCDE блок-Кип автоматик ✓ В блок-Төв үзелиэс В блок руу түгээх халаалтын магистрал шугам 	70%

70% ҮНЭЛГЭЭТЭЙ АРГА ХЭМЖЭЭ (4)

							<p>✓ ВСDE блок-Халаалтын холигч насосны узелийн ажлын зургуудыг бүрэн боловсруулагдаж улсын магадлалаар хянагдаж байна.</p> <p>Барилгын ажлын явц 85%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>"Спорт соёл үйлчилгээний цогцолбор"-ын барилгын ажилд 2019 онд Улсын төсвөөс 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Гадна пасад, усан бассейн, их заалны суудал суурилуулалт, дотор сантехникийн шугам угсралт зэрэг ажлууд хийгдэж "Спорт соёл үйлчилгээний цогцолбор"-ыг ашиглалтад оруулах явц 83%-тай явагдаж байна.</p>	
88	<p>6.7.9. Дархан-Уул аймагт өндөр настан тэтгэвэрт гарсан иргэдийн асран хамгаалах Герентологийн төв байгуулна.</p>	1	<p>Дархан-Уул аймагт өндөр настан тэтгэвэрт гарсан иргэдийн асран хамгаалах Герентологийн төв байгуулах</p>	2018 - 2019	НБХ	Зураг төсөл хийгдэх	<p>Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх "Герантологи"-ийн төв барихад шаардагдах 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудал шийдэгдсэн. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/471 дүгээр захирамжаар Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн урд талд 939 м2 талбай бүхий газрыг тус төвийг байгуулах зорилгоор олгох захирамжийн дагуу газрын гэрчилгээгээ авсан. Уг ажлын дагуу хөрсний геологийн дүгнэлт гаргуулах, барилга байгууламжийн схем зураг хийлгэх зэрэг ажлууд хийгдсэн. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх "Герантологийн төв"-ийн барилгыг барихад шаардагдах төсвийг Эрүүл мэндийн яамнаас 1,6 тэрбум төгрөг батлагдан, барилгын зураг төсөв хийгдэж, тендерт шалгарсан "Дорнын Өргөө" ХХК барьж байна. Барилгын гүйцэтгэл 70%-тай байна.</p>	70%

professional supportive
efficient polite
friendly good knowledgeable
timely helpful



ᠳᠠᠷᠬᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР